БАТЛАВ:

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ-Н

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНИКИЙН БОДЛОГЫН

ГАЗАРЫН ДАРГА

.....П.БАТБОЛОР

2025оны 06 сарын 26 өдөр

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

(SANDVIK МАРКИЙН ӨРМИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР, СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛ)

1. **ЗАХИАЛАГЧ:** ГЕОЛОГИ ХАЙГУУЛЫН ЭКСПЕДИЦИ
2. **ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ:**

-SANDVIK DE810 маркийн өрмийн төхөөрөмж. Бүртгэлийн дугаар №42-17600
- SANDVIK DE-740 маркийн өрмийн төхөөрөмж. Бүртгэлийн дугаар №42-18198

3. **ЗАСВАР, СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА:**

- Техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг зохих түвшинд хүргэх зорилгоор засвар үйлчилгээг жил болгон ижил давтамжтайгаар хийдэг.

- Үндсэн тоног төхөөрөмжийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангахын тулд засвар, сервис үйлчилгээг хийх шаардлагатай. / Дизель хөдөлгүүр, өрмийн төхөөрөмжийн цамхаг, эргүүлэгч, гидросистем болон гидронасос, шаврын насосуудад үзлэг оношилгоо, үйлчилгээ хийх/.

4. **ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ХЭМЖЭЭ, АЖИЛБАРУУД:**

- Дизель хөдөлгүүр / Cummins 6BTA5.9, Cummins 6CTA8.3/-т оношилгоо , тохиргоо хийх, түлшний систем, аппаратур форсункийг сэргээн засварлах тохируулах, масло болон түлшний шүүрүүдийг солих, клапан тохируулах, тосолгооны болон хөргөлтийн системийн үйлчилгээ хийх, хөдөлгүүрийн хэвийн ажиллагааг хангах;
- Гидросистем, гидромотор, гидронасоснуудын даралт шалгах, засварлах, гидрошингэний бак, шүүрнүүд болон шланг шалгаж, засварлах, гидро хуваарилагчуудын холбох хэсэг, гидрошингэний гоожилт болон эвдэрсэн эд ангийг шинээр солих;
- FMC-1122, FMC L1618 маркийн ус, шаврын насоснуудад үзлэг оношилгоо хийнэ. Ус шаврын насосны шатун, поршень, гильз, клапанд үзлэг хийж манжет плунжер г.м эд ангиудыг шинээр солих;
- Өрмийн төхөөрөмжийн цамхагт үзлэг үйлчилгээ, гулзайлт, хазайлт байгаа эсэх, цилиндрийн өргөх чадлыг шалгах, гинжний суналтыг шалгах, ролик болон пальцыг шинээр солих, замыг цэвэрлэж тосолгоо хийх;
- Эргүүлэгчид үзлэг, үйлчилгээ, тохиргоо хийнэ. Эргэлт хэвийн байгаа эсэх, гидросистемийн даралтыг хэмжих, арааануудын элэгдэл, холхивч, голны хэвийн ажиллагааг тодорхойлж тохиргоо хийнэ. Шаардлагатай сальникуудыг шинээр солих;

- Засвар бүрийн дараа комисс гарч шалгалт хийх.

5. **ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- Засварын ажлыг уул уурхайн хүнд механизм, тоног төхөөрөмжийн засварын ажлыг гүйцэтгэдэг, мэргэжлийн боловсон хүчний чадавхтай (механикч 1, тоног төхөөрөмжийн засварчин 2), гурваас доошгүй жилийн туршлагатай компани гүйцэтгэх;
- Засвар, сервис үйлчилгээний ажлыг жагсаалтын дагуу хийх. Хавсралт №1.

6. **АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:** Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш гэрээнд заасан хугацаанд улирал тутамд нэг удаа хийж гүйцэтгэх.

7. **АЖЛЫН ГЭРЭЭ:** 1 жилийн хугацаатай байгуулах.

8. **ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:** Батлагдсан төсвийн дагуу төлбөрийг хийх.

9. **АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН БАТАЛГАА:** Өрмийн төхөөрөмжүүдэд сервис үйлчилгээ хийж ажилд орсон өдрөөс 90 хоногийн баталгааг АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ гаргах.

ЗӨВШӨӨРСӨН:

МХ-ИЙН ДАРГА, ЕРӨНХИЙ МЕХАНИКЧ Б.ЧИНЗОРИГ

ХЯНАСАН:

ГХЭ-ИЙН ДАРГА М.ДАМДИНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

ГХЭ-ИЙН МЕХАНИКЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ

Хавсралт№1

# ӨРМИЙН ТӨХӨӨРӨМЖҮҮДЭД ХИЙГДЭХ ЗАСВАР, СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЖАГСААЛТ

| № | SANDVIK DE-810, SANDVIK DE-740 өрмийн төхөөрөмжүүдэд хийгдэх ажлын жагсаалт |
|---|---|
| **I** | **Өрмийн төхөөрөмжийн цамхагын үзлэг, тохиргоо, засвар:** |
| 1 | Өрмийн төхөөрөмжийн цамхагны хазайлт гулзайлт тодорхойлох |
| 2 | Өрмийн төхөөрөмжийн цамхагны роликуудыг шалгах, цэгэн тосолгоо хийх, маслянкуудыг шинээр солих |
| 3 | Өрмийн төхөөрөмжийн цамхагны төв цилиндрийн өргөх хүчин чадлыг хэмжих, тохируулах, сальникуудыг шинээр солих |
| 4 | Өрөмдлөгийн явц дахь өрмийн төхөөрөмжийн цамхагны төв цилиндэрт өгөх даралтыг хэмжих, зохих хэмжээнд тохируулах |
| 5 | Өрмийн төхөөрөмжийн цамхагны гинжний суналт, гинжний пальцуудыг шалгах, гинж сунасан, тунарсан бол тэнцүүлэх, чангалах, хасах, нэмэх, шинээр солих. |
| **II** | **Өрмийн төхөөрөмжийн эргүүлэгчийн засвар үйлчилгээ, үзлэг, оношилгоо хийх:** |
| 6 | Эргүүлэгчийн эргэлт хэвийн байгаа эсэхийг хэмжих, тохируулах |
| 7 | Эргүүлэгчийн гидрошингэний даралтыг хэмжих |
| 8 | Эргүүлэгчийн гидромоторын эргэлтийн хурд, даралт, мушгих хүчин чадлыг хэмжих, тохируулах |
| 9 | Хурдны хайрцгийн эргэлт хурднаас удаанд, удаанаас хурданд хэвийн шилжиж байгаа эсэхийг шалгаж тохиргоо хийх |
| 10 | Эргүүлэгчийн ноён арааны элэгдлийг шалгаж шаардлагатай бол шинээр солих |
| 11 | Эргүүлэгчийн голны холхивчуудыг шинээр солих |
| 12 | Эргүүлэгчийн голны сальникуудыг шинээр солих |
| 13 | Эргүүлэгчийн тосыг шинээр солих |
| 14 | Эргүүлэгчийн тосолгооны насосыг шинээр солих |
| 15 | Эргүүлэгчийн хөндлөн явагчийн цилиндрийн тохиргоо хийх, сальник шинээр солих |
| 16 | Эргүүлэгчийн голны сул явалтыг шалгаж тохируулах |
| 17 | Эргүүлэгчийн хавтасны гулгаа шалгах, шаардлагатай бол солих |
| 18 | Усны цутгалангийн холхивч, голны сальникуудыг шалгах, шинээр солих |
| 19 | Эргүүлэгчийн голны эргэлт тоологч буюу эргэлтийн хурд хэмжигчийг тохируулах |
| **III** | **Өрмийн төхөөрөмжийн дизель хөдөлгүүрийн ерөнхий байдалд үзлэг оношилгоо хийх:** |
| 20 | Өрмийн төхөөрөмжийн дизель хөдөлгүүрийг нам болон өндөр даралт өгч хэвийн ажиллагааг шалгах, компьютер оношилгоо хийх |
| 21 | Хөдөлгүүрийн тос шалгах, тест хийх, тос болон тосны шүүр шинээр солих |
| 22 | Түлшний шүүр болон тунгаагуур шинээр солих |
| 23 | Хөдөлгүүрийн эргэлтийн, даралтын , усны датчикуудыг шинээр солих |
| 24 | Аппаратурын тохиргоо хийх |
| 25 | Форсункуудын хэвийн ажиллагааг хангах, тохируулах |
| 26 | Аппаратурын түлшний даралт урсацыг хэмжих, тохируулах |
| **IV** | **Өрмийн төхөөрөмжийн гидросистемийн засвар үйлчилгээ, үзлэг, оношилгоо хийх :** |
| 27 | Өргөх эргүүлгийн гидромоторын өргөх хүч, эргэлтийн хурд зэргийг хэмжих, тохируулах |

| | |
|---|---|
| 28 | Өргөх эргүүлгийн дамарын холхивч шинээр солих |
| 29 | Дээжийн өргөх эргүүлгийн гидромоторын татах хүч, хурдыг хэмжих |
| 30 | Дээжийн өргөх эргүүлгийн дамарын холхивчийг шинээр солих |
| 31 | Өрмийн төхөөрөмжийн хянах самбарын бүрэн бүтэн байдлыг хангах, манометр болон бусад мэдрэгчүүдийн шинээр солих |
| 32 | Хуваарилагчуудын рычагнуудыг засварлах |
| 33 | Гидросистемийн хуваарилагчуудын холбох хэсгээр гидрошингэн гоожиж, хөлөрч байгаа эсэхийг шалгаж, жийргэвч нэмэх, чангалгаа хийх |
| 34 | Үндсэн гидронасосны гидрошингэний урсацын хурд, хүчин чадлыг хэмжих |
| 35 | Үндсэн гидронасосны гидрошингэн сорох хоолойг шинээр солих |
| 36 | Гидронасосноос гарж буй шлангуудын бүрэн бүтэн байдлыг шалгах, урсацын хурд, даралтыг хэмжих |
| 37 | Туслах гидронасосны гидрошингэний урсацын хурд, хүчин чадлыг хэмжих |
| 38 | Туслах гидронасосноос гарч буй шлангуудын бүрэн бүтэн байдлыг шалгах, урсацын хурд, даралтыг хэмжих |
| 39 | Шаардлага хангахгүй шлангууд, толгойнуудыг шинээр солих |
| 40 | Өрмийн төхөөрөмжийг газрын хэвгийд тэгшлэх, градустай өрөмдлөгт тааруулах зориулалт бүхий домкратын цилиндрүүдийн хэвийн ажиллагааг хангах |
| 41 | Домкратуудын хөлний хазайлт, тахийлт, боолтуудын сулралт байгаа эсэхийг шалгаж засварлах, тэгшлэх |
| 42 | Домкратууд болон бусад эд ангиуд руу явах шлангуудад буй үл буцах клапангуудыг шинээр солих |
| 43 | Сум баригчийн шүднүүдийг шалгах, шаардлагатай бол шинээр солих |
| 44 | Сум баригчийн цилиндрийн сальникийг шинээр солих |
| 45 | Агаар шүүгч болон гидрошингэний шүүрийг шинээр солих |
| 46 | Өрмийн төхөөрөмжийн хяналт хэмжилтийн багажуудыг / манометр / шалгах, тохиргоо хийх, шаардлагатй бол шинээр солих |
| **V** | **Өрмийн төхөөрөмжийн FMC-1122 FMC L1618 шаврын насоснуудад засвар үйлчилгээ, үзлэг, оношилгоо хийх** |
| 47 | Шаврын насосны редукторыг задлаж, холхивч, тахир гол, шилжүүлэгч араа, шатунь, поршен зэрэгт үзлэг тохиргоо хийх, шинээр солих |
| 48 | Шаврын насосны редукторын тосыг шалгах, солих |
| 49 | Шаврын насосны хэвийн ажиллагааг хангах, плунжерийн манжет, гильз, том, жижиг титэм, шток, сальник, холхивчуудыг шинээр солих |
| 50 | Шаврын насосны сорох шлангыг шинээр солих |
| 51 | Шаврын насосны даралтын манометрийг шинээр солих |

ЗӨВШӨӨРСӨН:

МХ-ИЙН ДАРГА, ЕРӨНХИЙ МЕХАНИКЧ Б.ЧИНЗОРИГ

ХЯНАСАН:

ГХЭ-ИЙН ДАРГА М.ДАМДИНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

ГХЭ-ИЙН МЕХАНИКЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ

Хавсралт №2

ӨРМИЙН ТӨХӨӨРӨМЖҮҮДЭД ЗАСВАР, СЕРВИС
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЕД ШИНЭЭР СОЛИХ СЭЛБЭГ, МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

| № | Сэлбэгийн нэр | Нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Gear box filter DE740 | ком | 2 | 452,147 | 904,294 |
| 2 | Traverse Seal Kit DE810 | ком | 2 | 435,054 | 870,108 |
| 3 | Mast Raise Seal Kit DE740 | ком | 4 | 193,091 | 772,364 |
| 4 | Mast Raise Seal Kit DE810 | ком | 4 | 355,727 | 1,422,908 |
| 5 | CHAIN TENSIONER & SPROCKET | ш | 2 | 387,470 | 774,940 |
| 6 | CHAIN ROLLER 1/2" 1575LG | ш | 2 | 173,087 | 346,174 |
| 7 | SUCTION HOSE; ID 3" X 810 LG | ш | 2 | 270,352 | 540,704 |
| 8 | FILTER ASSEMBLY | ком | 2 | 1,852,333 | 3,704,666 |
| 9 | BREATHER | ш | 4 | 121,760 | 487,040 |
| 10 | RESTRICTOR FIXED | ш | 4 | 478,026 | 1,912,104 |
| 11 | VALVE CHECK | ш | 4 | 307,514 | 1,230,056 |
| 12 | FILTER RETURN | ш | 2 | 2,449,454 | 4,898,908 |
| 13 | PLUNGER | ш | 4 | 432,808 | 1,731,232 |
| 14 | COVER | ш | 2 | 1,325,855 | 2,651,710 |
| 15 | NYLON BLOCK | ш | 2 | 711,904 | 1,423,808 |
| 16 | BEARING | ш | 4 | 67,618 | 270,472 |
| 17 | VALVE HANDLE | ш | 2 | 935,869 | 1,871,738 |
| 18 | Rod bearing FMC-1122 | ком | 1 | 1,456,876 | 1,456,876 |
| 19 | Ball valve FMC-1122 | ком | 1 | 2,588,227 | 2,588,227 |
| 20 | Cylinder kit FMC 1122 | ком | 1 | 1,895,470 | 1,895,470 |
| 21 | Rubber packing FMC 1122 | ком | 1 | 1,865,423 | 1,865,423 |
| 22 | Ажил үйлчилгээ (288хүн/цаг, томилолт, замын зардал) | | | 8,040,000 | 8,040,000 |
| 23 | Бусад | | | 8,340,778 | 8,340,778 |
| | НИЙТ ДҮН | | | | 50,000,000 |

ЗӨВШӨӨРСӨН:

МХ-ИЙН ДАРГА, ЕРӨНХИЙ МЕХАНИКЧ Б.ЧИНЗОРИГ

ХЯНАСАН:

ГХЭ-ИЙН ДАРГА М.ДАМДИНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

ГХЭ-ИЙН МЕХАНИКЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ